



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт,
үр нөлөө, үр дүн”

Сангийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөн, нэмэгдүүлж, арга хэмжээний гүйцэтгэл, хяналтын үр дүнг дээшлүүлснээр орон нутгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг сайжруулах боломжтой байна

Аудитын код: ДГА-2022/30-7-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2022 оны 06 сар

Дарга, тэргүүлэх аудитор: **Т.Ган-Өлзий**

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Аудитор:

Д.Дэмбэрэлсүрэн

Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Аудитор:

Ч.Хэрлэнчимэг

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:

Б.Алтанзул

Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	4
Хавсралтын товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ 1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу боломжит эх үүсвэрийг бүрэн төлөвлөж ажиллаагүй байна.	8
1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг бүрэн төлөвлөж хуваарилсан боловч зарим сумд хуульд заасан боломжит эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.	8
1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 95 хувь нь иргэдийн саналаар дэмжигдсэн, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн байна.	13
БҮЛЭГ 2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.	17
2.1 Сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааг явуулах, санхүүжилтийг олгохдоо холбогдох хууль тогтоомжийг бүрэн хангаж ажиллаагүй байна.	17
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нь сангийн зорилготой уялдсан боловч үр нөлөөг сайжруулах зорилгоор ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх шаардлагатай байна.	22
2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.	26
БҮЛЭГ 3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг журмын дагуу тайлагнаагүй байна.	28
3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан ч үр дүн хангалтгүй байна.	26
3.2 Төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг иж бүрэн, үнэн зөв боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна.	29
Аудитын дүгнэлт	36
Аудитын зөвлөмж	38
Холбогдох байгууллагын санал	44
Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулсан тушаал	47

Товчилсон үгийн тайлбар

АМХБАТЗ	Ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн хурал
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НААУ	Нийтийн аж ахуйн үйлчилгээ
ОНӨ	Орон нутгийн өмчит
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт № 1	ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг
Хүснэгт № 2	Дорноговь аймагт 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ТАХ-ний тоо
Хүснэгт № 3	Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоолол
Хүснэгт № 4	Аймаг, сумдын ОНХС-д олгосон төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт № 5	Өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлийн төлөвлөлт
Хүснэгт № 6	2021 онд хийгдэх ИТХ-аар батлуулсан ТАХ-ний тоо
Хүснэгт № 7	Үнийн харьцуулалт
Хүснэгт № 8	Тендер шалгаруулалттай холбоотой 2021 онд гарсан гомдол
Хүснэгт № 9	Аймаг, сумдын ОНХС-ийн гүйцэтгэл
Хүснэгт № 10	ОНХС-ийн 2021 оны шинээр хэрэгжсэн ТАХ-ний зарцуулалт
Хүснэгт № 11	ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ТАХ-ний хэрэгжилт
Хүснэгт № 12	ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний жагсаалт
Хүснэгт № 13	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ
Хүснэгт № 14	Нягтлан бодох бүртгэлд тусгах арга хэмжээ

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График № 1	ОНХС-ийн 2019-2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл
График № 2	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
График № 3	ОНХС-ийн хөрөнгийг Орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байдал
График № 4	ОНХС-аар хийгдэх арга хэмжээний тоо
График № 5	Сонгон шалгаруулалтын арга
График № 6	Хэрэгжсэн ТАХ-ний ангилал

Зургийн товъёог:

Утга	Тайлбар
Зураг № 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8	Дутуу хийгдсэн болон хийгдэж байгаа ажлууд
Зураг № 9, 10	Хөрөнгийн ашиглалтын байдал
Зураг № 11, 12	Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал
Зураг № 13	ОНХС-ийн УМС нэгтгэсэн мэдээллийг харуулсан хэсэг
Зураг № 14	ОНХС-ийн УМС арга хэмжээг дэлгэрэнгүй харуулсан хэсэг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - ОНХС-ийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх - ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх - ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх
Аудитын хамрах хүрээ	ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон Сангийн яам болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, БИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	Цаг хугацааны хязгаарлалтаас сумдад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзэх боломжгүй болж, холбогдох ажилтнуудтай утсаар мэдээлэл солилцон, тайлбар тодруулга авч, ТАХ-ний гүйцэтгэлийн зургийг цахимаар авч, аудитыг баримтад үндэслэн хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
- Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдан зохион байгуулж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Мөнхтогтох, аудитор Д.Дэмбэрэлсүрэн, аудитор Ч.Хэрлэнчимэг, аудитор Б.Алтанзул нар хамтран гүйцэтгэв.

Аудитыг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхэлж, аудитын тайланг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор нэгтгэн, дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл

Зарим сумд баримт материалыг цаг хугацаанд нь бүрэн хэмжээгээр ирүүлээгүйгээс аудитыг цаг хугацаанд нь гүйцэтгэхэд хүндрэлтэй байв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС-аас Дорноговь аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 19,069.5 сая төгрөгөөр баталж, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн төсвийн нэмэлт өөрчлөлтөөр 266.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 19,336.3 сая төгрөгөөр баталсан байна. /хүснэгт 1/

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг

№	Аймаг	Сумын тоо	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	Хүснэгт №1 /сая төгрөгөөр/ Үүнээс “Тогтвортой амьжиргаа 3” төслийн	
				Дэмжлэг	Урамшуулал
1	Дорноговь	14	19,336.3	107.1	301.8

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль

“Тогтвортой амьжиргаа 3” төслөөс 2021 онд 107.1 сая төгрөгийн дэмжлэг, 301.8 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

Дорноговь аймагт 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ТАХ-ний тоо

Д/д	Сумын нэр	Өмнөх оноос шилжиж ирсэн	2021 онд хэрэгжүүлэх	Хүснэгт №2 Нийт	
				Дэмжлэг	Урамшуулал
1	Айраг	4	11	15	
2	Алтанширээ	-	14	14	
3	Даланжаргалан	8	5	13	
4	Дэлгэрэх	-	17	17	
5	Иххэт	-	7	7	
6	Мандах	2	4	6	
7	Өргөн	1	3	4	
8	Сайхандулаан	4	20	24	
9	Улаанбадрах	1	7	8	
10	Хатанбулаг	-	10	10	
11	Хөвсгөл	2	11	13	
12	Эрдэнэ	-	8	8	
13	Сайншанд	3	24	27	
14	Замын-Үүд	4	10	14	
15	Аймаг	10	4	14	
Нийт		39	155	194	

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол

Өмнөх оноос шилжиж ирсэн 39, тайлант онд хэрэгжүүлэх 155, нийт 194 төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн 40.8 хувийг барилга байгууламж, дэд бүтэц, засварын ажил, 30.6 хувийг тоног төхөөрөмж, камержуулалт, гудамжны гэрэлтүүлэг, 14.6 хувийг жишиг гудамж, тоглоомын талбай, зураг төсөв, 14.0 хувийг өвс, худаг усны ажил эзэлж байна.

Санхүүжилт олгосон байдлыг авч үзвэл сумдын ОНХС-д нийт 8,190.8 сая, тохижилт үйлчилгээний зардалд 59.1 сая, мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 148.8 сая, аймгийн ОНХС-д 10,937.6 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу боломжит эх үүсвэрийг бүрэн төлөвлөж ажиллаагүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг бүрэн төлөвлөж хуваарилсан боловч зарим сумд хуульд заасан боломжит эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

1.1.1 ОНХНС-ийн орлогын бүрдүүлэлт нь тус аудитын газрын шалгах асуудалд хамаарахгүй болно.

1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож, санхүүжилтийг бүрэн хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59.3-т “ОНХС-аас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлох итгэлцүүрээр тогтооно”, 59.3.1-д “Орон нутгийн хөгжлийн индекс”, 59.3.2-д “Хүн амын тоо”, 59.3.3-д “Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ”, 59.3.4-д “Орон нутгийн татварын идэвх санаачилга” зэрэг үзүүлэлтүүдийг харгалзаж сумдад олгох орлогын шилжүүлгийг дараах байдлаар хуваарилахаар төлөвлөсөн байна.

Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоолол

Хүснэгт №3 /сая төгрөгөөр/

№	Сум	Итгэлцүүрээр тооцсон дүн				ТА-3 төслийн урамшуулал, дэмжлэг	АМХБАТЗ-ийн төлбөр	Суурь зарлага	Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр	Сумдын ОНХС-д төлөвлөж хуваарилсан суурь дүн
		Алслалтаас хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 30%	Итгэлцүүрээр хуваарилагдсан нийт дүн					
1	Айраг	83.6	94.1	85.5	263.2	24.7	331.7	-	-	619.6
2	Алтанширээ	21.6	32.8	83.2	137.5	12.9	223.9	-	-	374.3
3	Даланжаргалан	72.0	67.9	47.4	187.3	25.3	269.8	-	-	482.3
4	Дэлгэрэх	43.8	46.3	55.4	145.5	23.6	157.8	-	-	326.9
5	Замын-Үүд	655.3	450.6	4.6	1,110.5	149.7	-	-	-	1,260.3
6	Иххэт	63.4	52.1	48.5	164.0	22.1	156.9	-	-	343.0
7	Мандах	47.7	39.2	146.7	233.6	31.5	236.3	-	-	501.4
8	Өргөн	22.0	49.5	100.5	172.0	23.2	204.0	-	-	399.2
9	Сайншанд	-	612.0	26.6	638.5	16.2	129.3	59.1	-	843.2
10	Сайхандулаан	23.7	34.1	109.7	167.5	4.3	324.6	-	-	496.4
11	Улаанбадрах	34.9	36.3	131.7	202.8	5.2	629.4	-	-	837.4
12	Хатанбулаг	111.1	72.1	216.0	399.1	37.4	397.2	-	-	833.8
13	Хөвсгөл	44.5	38.9	97.0	180.4	4.6	429.3	-	-	614.3
14	Эрдэнэ	40.0	58.7	110.9	209.6	28.3	80.1	-	-	318.0
	Нийт	1,263.5	1,684.6	1,263.5	4,211.6	409.0	3,570.3	59.1	-	8,250.0
15	Аймгийн ОНХС	-	-	-	10,694.2	-	-	125.4	266.8	11,086.4
	Аймгийн нийт дүн	1,263.5	1,684.6	1,263.5	14,905.8	409.0	3,570.3	184.5	266.8	19,336.3

Сангийн сайдын 2017 оны 230 дугаар тушаалаар баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 8.2-т ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилахдаа алслалт болон газар нутгийн хэмжээнээс тус бүр 30 хувь, хүн амын тооноос 40 хувиар хамааруулж тооцохоор тусгасан байна.

ОНХНС-аас сумдад олгох шилжүүлгийг дээрх аргачлалд үндэслэн итгэлцүүрийн дагуу тооцсон байна.

Тайлант онд ОНХНС-аас аймгийн ОНХС-д 18,927.3 сая төгрөг, сумдын ОНХС-д тогтвортой амьжиргаа 3 төслөөс 409.0 сая төгрөг, нийт 19,336.3 сая төгрөгийг хуваарилахаар баталж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

1.1.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.2-т ОНХНС-аас олгох ОНХС-ийн шилжүүлгийг хууль, журамд заасны дагуу ... сумын ОНХС-д хуулийн хугацаанд шилжүүлэхээр тусгажээ.

Аймгийн ОНХС-аас сумдад 7,840.9 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 409.0 сая төгрөг, нийт 8,249.9 сая төгрөгийг шилжүүлэхээр тооцож, төлөвлөгөөний дагуу хуваарилсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №4 /сая төгрөгөөр/


№	Сум	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү		
		ТА-3 төслө өс	ОНХС	Нийт	ТА-3 төслө с	ОНХС	Нийт	ТА-3 төсл өөс	ОНХС	Нийт
1	Айраг	24.7	594.9	619.6	24.7	594.9	619.6	-	-	-
2	Алтанширээ	12.9	361.4	374.3	12.9	361.4	374.3	-	-	-
3	Даланжаргалан	25.3	457.1	482.4	25.3	457.1	482.4	-	-	-
4	Дэлгэрэх	23.6	303.3	326.9	23.6	303.3	326.9	-	-	-
5	Замын-Үүд	149.7	1,110.5	1,260.2	149.7	1,110.5	1,260.2	-	-	-
6	Иххэт	22.1	320.8	342.9	22.1	320.8	343.0	-	-	-
7	Мандах	31.5	469.9	501.4	31.5	469.9	501.4	-	-	-
8	Өргөн	23.2	376.0	399.2	23.2	376.0	399.2	-	-	-
9	Сайншанд	16.2	827.0	843.2	16.2	827.0	843.2	-	-	-
10	Сайхандулаан	4.3	492.1	496.4	4.3	492.1	496.4	-	-	-
11	Улаанбадрах	5.2	832.3	837.5	5.2	832.3	837.5	-	-	-
12	Хатанбулаг	37.4	796.3	833.7	37.4	796.3	833.7	-	-	-
13	Хөвсгөл	4.6	609.6	614.2	4.6	609.6	614.2	-	-	-
14	Эрдэнэ	28.3	289.7	318.0	28.3	289.7	318.0	-	-	-
Сумдын нийт дүн		409.0	7,840.9	8,249.9	409.0	7,840.9	8,249.9	-	-	-
15	Аймаг	-	11,086.4	11,086.4	-	11,086.4	11,086.4	-	-	-
Бүгд дүн		409.0	18,927.3	19,336.3	409.0	18,927.3	19,336.3	-	-	-

Аймгийн ОНХС-ийн нийт 19,336.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн 57.3 хувь буюу 11,086.4 сая төгрөгийг аймаг, 42.7 хувь буюу 8,249.9 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

ОНХС-ийн нийт орлогын шилжүүлэг нь 2019-2021 онуудад жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

ОНХС-ийн 2019-2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл

График №1 /сая төгрөгөөр/



Аймгийн ОНХС-д нийт шилжүүлгийн 40-60 хувийг хуваарилсан боловч тус сангаас хийгдэж буй ажлууд нь ихэвчлэн сумдын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад чиглэгджээ.

1.1.4 Малын тоо толгойн албан татвар, сангийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлийг зарим сумд ОНХС-ийн эх үүсвэрт тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 60.2-д Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж;
- Дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- Малын тоо толгойн албан татварын орлого гэж заасан байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолд ОНХС-аас олгох шилжүүлэг, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, гадаад дотоодын хандив, малын тоо толгойн албан татварын орлогыг тусгаж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

ОНХС-ийн орлогын шилжүүлэг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшуулал, дэмжлэгийг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Гадаад, дотоодын хандив

Аймгийн Засаг дарга тухайн орон нутагт үйл ажиллагааг явуулж байгаа “Доншен газрын тос Монгол” ХХК, “Смарт ойл Монголиа” ХХК, “Зон Хэ Юу Тиан” ХХК-уудтай, Хатанбулаг, Хөвсгөл сумдын Засаг дарга “Си Өү Эй Эл” компанитай нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хандив тусламж үзүүлэх гэрээг байгуулжээ.

Гэрээний заалтын дагуу тайлант онд аймаг 186.0 сая, Хатанбулаг сум 80.0 сая, Хөвсгөл сум 20.0 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргаас хандивын орлогыг ОНХС-д төвлөрүүлэх талаар 2021 оны 10 дугаар сард албан бичгийг дээрх 3 компанид хүргүүлж, “Смарт ойл Монголиа” ХХК-аас 171.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба “Доншен газрын тос Монгол” ХХК, “Зон Хэ Юу Тиан” ХХК-ууд шилжүүлээгүй байна.

Хатанбулаг, Хөвсгөл сумдын ОНХС-д “Си Өү Эй Эл” ХХК-аас 100.0 сая төгрөгийн хандивыг шилжүүлсэн байна.


Дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлэх хандивын орлогыг үндэслэлтэй тооцож, бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгөв.

Малын тоо толгойн албан татвар

Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 11 сумын ИТХ-ын тогтоолд тус татварын орлогоос нийт 372.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна. Айраг, Даланжаргалан, Хатанбулаг сумд малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сумдаар/

График №2 /сая төгрөгөөр/



Малын тоо толгойн албан татварыг төсвийн орлогод дээрх 11 сум тусгаж баталсан боловч Өргөн, Хөвсгөл, Замын-Үүд сумд ОНХС-ийн эх үүсвэрт тусгаагүй, өөрөөр хэлбэл 54.0 сая төгрөгийн эх үүсвэрийг орхигдуулан төлөвлөжээ.

ОНХС-ийн эх үүсвэрт тус татварын орлогыг төлөвлөсөн 8 сумд 318.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр тооцож, гүйцэтгэлээр 365.1 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 14 хувиар давуулан биелүүлсэн байна. Тус орлогыг төлөвлөгөө бүрэн биелсэн боловч уг эх үүсвэрээр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл 33 хувьтай байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуульд татварын орлогыг тухайн жилийн 7 болон 12 дугаар саруудад төвлөрүүлэхээр заасан, Ковид 19 цар тахлын тархалттай холбоотойгоор татварыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл чөлөөлсөн, татварын орлогын бүрдүүлэлтийн 80 хувь нь тайлан оны 12 дугаар сард төвлөрсөнтэй холбоотой байна.

Тус татварын орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөөгүй Айраг, Даланжаргалан, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Замын-Үүд сумд Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан бэлчээрийн менежментийг сайжруулах, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх сумдад малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөх талаар зөвлөмж өгөв.

Сангийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл

Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8-д “ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган, ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ” гэж заасан.

Алтанширээ, Даланжаргалан, Замын-Үүд, Сайншанд, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумд 2020 оны зарцуулагдаагүй үлдэгдэл болох нийт 1,137.1 сая төгрөгийг сумдын ИТХ-ын тогтоолд тусгаж, батлуулсан байна.

Эрдэнэ, Хөвсгөл сумд 175.2 сая төгрөгөөр тус эх үүсвэрийг дутуу, Сайншанд, Замын-Үүд сумд 83.2 сая төгрөгөөр илүү тооцож төлөвлөсөн байна.

Харин аймгийн ОНХС болон Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан сумд нийт 446.2 сая төгрөгийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлийг ИТХ-аар батлуулаагүй нь дээрх хуулийн заалтыг зөрчсөн байна.

Өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлийн төлөвлөлт

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Зарцуулагдаагүй үлдэгдэл				
		Өмнөх оны үлдэгдэл	ИТХ-аар баталсан үлдэгдэл	Зөрүү	Үүнээс:	
					Дутуу төлөвлөсөн	Илүү төлөвлөсөн
1	Айраг	115.4	-	(115.4)	(115.4)	-
2	Алтанширээ	67.1	67.1	-	-	-
3	Даланжаргалан	450.0	450.0	-	-	-
4	Дэлгэрэх	26.0	-	(26.0)	(26.0)	-
5	Замын-Үүд	52.9	115.3	62.4	-	62.4
6	Иххэт	24.5	-	(24.5)	(24.5)	-
7	Мандах	1.0	-	(1.0)	(1.0)	-
8	Өргөн	75.6	-	(75.6)	(75.6)	-
9	Сайншанд	3.5	24.3	20.8	-	20.8
10	Сайхандулаан	73.5	-	(73.5)	(73.5)	-
11	Улаанбадрах	196.0	196.0	-	-	-
12	Хатанбулаг	9.6	9.6	-	-	-
13	Хөвсгөл	311.8	137.8	(174.0)	(174.0)	-
14	Эрдэнэ	46.2	45.0	(1.2)	(1.2)	-
Сумдын нийт дүн		1,453.1	1,045.1	(408.0)	(491.2)	-
15	Аймаг	130.2	-	(130.2)	(130.2)	-
Бүгд дүн		1,583.3	1,045.1	(538.2)	(621.4)	83.2

Өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг нийт 704.6 сая төгрөгөөр зөрүүтэй төлөвлөж, баталсан байна.

Аймаг, сумд нь ОНХС-ийн эх үүсвэрийг үндэслэлтэй тооцож, төлөвлөх шаардлагатай байна.

Аймгийн Засаг дарга болон Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан сумдын Засаг даргад сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх зөвлөмж өгөв.

1.2 ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 95 хувь нь иргэдийн саналаар дэмжигдсэн, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн байна.

1.2.1 Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 5 хувь нь иргэдийн саналаар дэмжигдээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч ИНХ-аар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтлөн эрэмбэлж, ЗДТГ-ын ажлын хэсэгт хүргүүлсэн байна. Сумдын ЗДТГ-ын ажлын хэсэг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой уялдуулан эрэмбэлж ИТХ-аар батлуулсан боловч иргэдийн саналаар дэмжигдээгүй зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтоолд тусгажээ.

Дорноговь аймгийн хэмжээнд нийт 155 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна. Хүснэгт №6

2021 онд хийгдэх ИТХ-аар батлуулсан ТАХ-ний тоо

Хүснэгт №6

№	Сумын нэр	Төлөвлөгөө		
		Хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ	Төсөвт өртөг /сая төгрөгөөр/
1	Айраг	11	-	-
2	Алтанширээ	14	-	-
3	Даланжаргалан	5	-	-
4	Дэлгэрэх	17	-	-
5	Замын-Үүд	10	-	-
6	Иххэт	7	2	82.3
7	Мандах	4	-	-
8	Өргөн	3	-	-
9	Сайншанд	24	-	-
10	Сайхандулаан	20	-	-
11	Улаанбадрах	7	2	540.3
12	Хатанбулаг	10	-	-
13	Хөвсгөл	11	3	235.1
14	Эрдэнэ	8	-	-
Сумдын нийт дүн		151	7	857.7
15	Аймаг	4	-	-
Бүгд дүн		155	7	857.7

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Иххэт суманд хэрэгжсэн нийт 82.3 сая төгрөгийн “Сумын төвийн хаягжуулалт”, “ЕБС-ийн сургуулийн дотуур байрны гадна фасадны заслын засвар”-ын ажил;
- Улаанбадрах суманд хэрэгжсэн нийт 540.3 сая төгрөгийн “Сумын ЗДТГ-ын барилгыг өргөтгөж, Иргэдэд үйлчлэх цогцолбор төв байгуулах” ажил;
- Хөвсгөл суманд хэрэгжсэн нийт 235.1 сая төгрөгийн “Хогийн машин худалдаж авах”, “Гудамжны гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил”, “ЭМТ-ийн эмч нарын орон сууц барих” ажил байна.

Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдын Засаг даргад алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Сайхандулаан сум 519.5 сая төгрөгийн 20, Хатанбулаг сум 745.8 сая төгрөгийн 7 төсөл хөтөлбөрт иргэдээс санал авч хэлэлцүүлсэн гэх боловч холбогдох баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй болно.

Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.2-д “Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна”, 5.2.1-д “санал асуулгын хуудас”, 5.2.2-д “бүлгийн ярилцлага, 5.2.3-д “цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр”-ээр саналыг авна гэж заасан байна.

Тайлант онд 14 суманд ОНХС-аар хийгдэх 774 төсөл арга хэмжээнд 8,936 иргэдээс саналын хуудсаар, 1,140 иргэдээс цахимаар тус тус санал авсан байна.

“Ковид-19” цар тахлаас шалтгаалан Сайншанд, Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ сумууд ИНХ-ыг зохион байгуулах боломжгүй байсан тул, иргэдээс ирсэн саналыг багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн эрэмбэлж сумын Засаг даргад хүргүүлж ажилласан байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.


Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасан.

Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэсний нэгдмэл үндсэн чиглэл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, орон нутгийн хөгжил гэсэн 8 зорилгыг дэвшүүлжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 155 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь дээрх үндсэн чиглэлийн зорилттой бүрэн уялдсан байна.

ОНХС-ийн хөрөнгийг Орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байдал

График №3



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудын 62 хувь нь “Амар тайван, аюулгүй нийгэм”, 12 хувь нь “Ногоон хөгжил”, 10 хувь нь “Хүний хөгжил”, 9 хувь нь “Орон нутгийн хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн байна.

“Дорноговь аймгийн 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө” богино хугацааны бодлогын баримт бичиг нь “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийг засаг, нийгмийн хүндрэлийг давах туулах, хүний хөгжил, эдийн засгийн бодлого, засаглалын бодлого, ногоон хөгжлийн бодлого, орон нутаг, хөдөөгийн хөгжил гэсэн 8 зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 7 ТАХ нь дээрх богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.

1.2.3 Аймаг, сумдад ОНХС-аар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээ нь тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарсан байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх дараах чиг үүргийг заасан байна.

ОНХС-аар хийгдэх арга хэмжээний тоо /чиг үүрэг тус бүрээр/

График №4



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 155 ТАХ нь аймаг, сумын Засаг даргын дээрх чиг үүрэгт хамаарсан боловч ажлын байр бий болгох, өрхийн орлогыг дэмжих чиглэлээр ажил төлөвлөөгүй байна.

Орчны тохижилт, ногоон байгууламж болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг дэмжихэд нийт ажлын 60 хувь нь чиглэгдсэн ба үүнд тоглоомын талбай байгуулах, жишиг гудамж, гэрэлтүүлэг, биеийн тамирын талбайн тохижилт, Халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга цэвэрлэх байгууламж барих, ЭМТ-ийн засвар, ЕБС-ийн байрны засвар зэрэг ажлууд багтаж байна.

1.2.4 ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөв батлагдаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж заасан байна.

Хуулийн дээрх заалтыг зөрчин зураг, төсөвгүй дараах ТАХ-г баталсан байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын 15.0 сая төгрөгийн “Мал тарилгын нэгдсэн хашаа”, 58.7 сая төгрөгийн “Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл”, 30.2 сая төгрөгийн “Багийн төвд өвсний фонд барих”, 46.1 сая төгрөгийн “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” ажил;
- Иххэт сумын 73.9 сая төгрөгийн “Сумын төвийн гэрэлтүүлэг хийх” ажил;
- Мандах сумын 188.4 сая төгрөгийн “Иргэдэд үйлчлэх танхим шинээр барих”, “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах”, 50.0 сая төгрөгийн “ЕБС-ийн барилгын их засварын” ажил;
- Өргөн сумын 124.7 сая төгрөгийн “Сумын төвийн орон сууцнуудын дээвэр засварлах /2 3 4 5/”, “Сумын төвийг камержуулах” ажил;
- Сайхандулаан сумын 10.0 сая төгрөгийн “Улааншороот багийн иргэдэд үйлчлэх төвийн засвар”, 9.0 сая төгрөгийн “Бэлчээрийн болон газар тариалангийн гар худгийн усан хангамжийг нэмэгдүүлэх” ажил;

- Хөвсгөл сумын 150.1 сая төгрөгийн “ЭМТ-ийн эмч нарын орон сууц барих ажил”, 243.8 сая төгрөгийн “Төсөвт байгууллагуудын дулааны шугам шинээр тавих” ажил;
- Замын-Үүд сумын 312.4 сая төгрөгийн “2.6 км дугуйн зам болон гэрэлтүүлэг хийх ажил”, 198.7 сая төгрөгийн “Соёмбо цогцолборын засвар шинэчлэлтийн” ажил.

Сумын ИТХ-аар төсөв тооцоо хийгдээгүй, батлагдсан зураггүй ТАХ-г батлах, зураг төсвийг тогтоол батлагдсаны дараа хийлгэж байгаа нь ажлын төсөвт өртөгт дахин өөрчлөлт орох, чанаргүй хөрөнгө бий болох эрсдэлийг үүсгэж байна.

Иймд Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хөвсгөл, Замын-Үүд сумдын холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөв.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих ТАХ-г бодит өртөг, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөдөггүйгээс ТАХ-ний төсөвт өртөгт өөрчлөлт оруулж, 2021 онд төсвийн тодотголыг хийсэн байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.


2.1 Сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааг явуулах, санхүүжилтийг олгохдоо холбогдох хууль тогтоомжийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

2.1.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан боловч үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 155 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан бөгөөд сонгон шалгаруулалтыг графикт харуулав. /График №5/

Сонгон шалгаруулалтын арга

График №5



Үүнд: Харьцуулалтын аргаар 52 хувь буюу 81, шууд гэрээ байгуулах аргаар 27 хувь буюу 42, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 19 хувь буюу 29, олон нийтийн оролцооны аргаар 2 хувь буюу 3 худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 2021 оны бүх тендер шалгаруулалтыг цахимаар явуулсан байна.

Тендерийг хуулийн дагуу явуулах үүрэг бүхий үнэлгээний хороог Сайхандулаан сум 3, бусад сумд 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Засаг даргын захирамжаар байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.6-д Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэж заасан. Гэтэл худалдан авах ажиллагааны сертификатын хүчинтэй хугацаа дууссан үнэлгээний хорооны гишүүнийг Айраг сум 1, Алтанширээ сум 1, Сайхандулаан сум 3 ТАХ-ний тендер шалгаруулалтад оролцуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ... орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг ... оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тодруулбал:

- Иххэт сум 6 ТАХ;
- Сайхандулаан сум 11 ТАХ;
- Улаанбадрах 3 ТАХ;
- Хатанбулаг сум 6 ТАХ.

Цаашид үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ИТХ-аас томилсон иргэнийг оролцуулж байх зөвлөмжийг Иххэт, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдын Засаг дарга нарт өгөв.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.5-д бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх гэж заасан.

ХАА-г батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг хоцроож зарласан 27 ТАХ байна. Үүнд:

- Сайншанд сум 4 ТАХ ажлын 12-65 хоног;
- Сайхандулаан сум 14 ТАХ ажлын 37-170 хоног;
- Улаанбадрах сум 1 ТАХ ажлын 126 хоног;
- Хөвсгөл 3 ТАХ ажлын 18-25 хоног;
- Эрдэнэ сум 5 ТАХ ажлын 28-72 хоног.

Зарласан тендерт оролцогч оролцоогүй, мөн шаардлагад нийцсэн материал ирүүлээгүй шалтгаанаар 12 суманд 35 ТАХ-ний ХАА-г 2 болон түүнээс дээш удаа зохион байгуулсан байна. Үүнд:

- Айраг сум 4 ТАХ;
- Алтанширээ сум 4 ТАХ;
- Даланжаргалан сум 4 ТАХ;
- Дэлгэрэх сум 3 ТАХ;
- Иххэт сум 1 ТАХ;
- Мандах сум 2 ТАХ;
- Өргөн 1 ТАХ;
- Сайхандулаан сум 4 ТАХ;
- Хатанбулаг сум 2 ТАХ;
- Хөвсгөл сум 1 ТАХ;
- Замын-Үүд сум 2 ТАХ;
- Сайншанд сум 7 ТАХ.

Сумдад зохион байгуулсан 151 ТАХ-ний 23 хувь нь оролцогч болон шаардлага хангасан тендерийн материалтай холбоотойгоор ХАА-ны хугацаа уртасч удааширсан байна.

Аймаг, суманд зарлагдсан ХАА-нд сонгон шалгаруулалтын аргыг мөрдөж ажилласан боловч 1 ажлыг хууль, журмын заалтыг зөрчин сонгон шалгаруулсан байна. Үүнд:

- Сайншанд сумын “1, 2, 3, 8 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай” байгуулах нийт 180.2 сая төгрөгийн ажлыг 45.0 сая, 33.7 сая, 41.4 сая, 60.1 сая төгрөгөөр задалж харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Энэ нь хууль, журамд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно, харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар ажлын хувьд 80.0 сая төгрөг гэж заасныг зөрчсөн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-д “гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэж заасан байхад тендерийн хүчинтэй байх хугацаа дууссаны дараа буюу 30-аас дээш хоногийн дараа гэрээг байгуулжээ. Тухайлбал:

- Сайхандулаан суманд 1 ТАХ-ний гэрээг эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш 38 хоногийн дараа;
- Эрдэнэ суманд 2 ТАХ-ний гэрээг эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш 42, 46 хоногийн дараа байгуулжээ.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртөг нь үнэн зөв эсэхэд магадлал хийдэггүйгээс ижил төстэй төсөл, арга хэмжээг харилцан адилгүй өртгөөр гүйцэтгэсэн буюу эх үүсвэрийг арвилан хэмнэлтгүйгээр зарцуулах нөхцөл болсон байна. /Хүснэгт №7/

Үнийн харьцуулалт

		Хүснэгт №7 /сая төгрөгөөр/		
Д/д	Сумын нэр	Төсөл арга хэмжээний нэр	Үнэ	Зөрүү
1	Хөвсгөл	Хог зөөврийн автомашин	34.2	-
2	Хатанбулаг		40.0	5.8
3	Замын-Үүд		63.7	29.5
1	Алтанширээ	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	19.9	-
2	Дэлгэрэх		43.0	23.1
3	Сайншанд		45.0	25.1
4	Мандах		57.7	37.8

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.3-д “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна”, 28.7.3-д “энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно”, 28.7.4-д “хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ”, 33 дугаар зүйлийн 33.2.2-д “техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох” гэж заасны дагуу сумд хамгийн бага үнийн санал ирүүлсэн тендерийг шалгаруулж ажилласан байна.

Гэвч зарим сумдаас хамгийн бага үнийн санал ирүүлсэн компанийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэх нь сул талтай байна гэсэн саналыг уламжилж байв.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 55.1-д заасны дагуу 4 ажлын тендерийн үнэлгээтэй холбоотой оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Тендер шалгаруулалттай холбоотой 2021 онд гарсан гомдол

Хүснэгт №8

№	Гомдол гаргасан огноо	Захиалагч байгууллага	Тендер шалгаруулалтын нэр	Гомдол гаргагч байгууллага	Шийдвэрлэсэн байдал
1	2021 оны 03 сар	Айраг сумын ЗДТГ	Точик байрны тоглоом нэмэгдүүлэх	Уран төмөр хэлхээ ХХК, Хүрэл соёмбо ХХК	Гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй
2	2021 оны 03 сар	Сайншанд сумын ЗДТГ	Сайншанд сумын 2 дугаар багт гэр хорооллын гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил	Оджи од ХХК	Үнэлгээг дахин хийх
3	2021 оны 03, 04 сар	Замын-Үүд сумын ЗАА	Хог тээврийн 2 ширхэг автомашин худалдан авах	Нутгийн буян групп ХХК	Гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах
4	2021 оны 05 сар	Иххэт сумын ЗДТГ	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны дээврийн засварын ажил	Ихэр түрүү ХХК	Үнэлгээг дахин хийх

Эх сурвалж: www.mof.gov.mn – Тендерийн гомдол шийдвэрлэлт /Сангийн яам/

Дээрх маргааныг Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Сайншанд сум тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийж, гүйцэтгэгч хэвээр үлдсэн байна.

Иххэт сум гомдлын дагуу үнэлгээг дахин хийх үед тендерийн хүчинтэй байх хугацаа дууссан учир Сангийн яамнаас тендер шалгаруулалтыг дахин хийх чиглэлийг өгч ХАА-г шинээр зохион байгуулсан байна.

Дээрхээс үзэхэд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг мөрдөж, үнэлгээний хорооны гишүүдийг мэргэжлийн арга зүйгээр ханган, цаашид тендер шалгаруулах ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.1.2 ОНХС-аас 78.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заасны дагуу 2021 оны шинээр хэрэгжсэн ТАХ-нд 9,611.3 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна. Хүснэгт №10

Аймаг, сумдын ОНХС-ийн гүйцэтгэл

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

Д/д А	Сумын нэр Б	Эхний үлдэгдэл 1	Орлого 2	Зарлага 3	Эцсийн үлдэгдэл 4=1+2-3
1	Айраг	115.4	627.8	492.8	250.4
2	Алтанширээ	67.1	439.5	386.8	119.8
3	Даланжаргалан	450.0	491.7	681.1	260.6
4	Дэлгэрэх	26.0	397.1	396.9	26.2
5	Иххэт	125.1	1,268.2	1,250.5	142.8
6	Мандах	24.5	360.9	325.7	59.7
7	Өргөн	1.0	561.7	512.4	50.3
8	Сайхандулаан	75.6	447.2	244.1	278.7
9	Улаанбадрах	3.5	822.7	739.2	87.0
10	Хатанбулаг	73.5	520.1	293.5	300.1
11	Хөвсгөл	196.0	894.6	626.5	464.1
12	Эрдэнэ	9.6	913.8	911.7	11.7
13	Сайншанд	311.8	669.8	294.0	687.6
14	Замын-Үүд	46.2	370.0	341.4	74.8
15	Аймаг	62.8	11,440.6	10,061.5	1,441.9
	Нийт	1,588.1	20,225.7	17,558.1	4,255.7

Аймаг, сумдын ОНХС-ийн дансны эхний үлдэгдэлтэй 1,588.1 сая төгрөг, тайлант онд нийт 20,225.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, ТАХ-нд 17,558.1 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,255.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар гүйцэтгэгч компанид олгосон санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрч төлбөрийн акт, албан шаардлагыг өгсөн. Үүнд:

- Мандах сумын "Төрийн албан хаагчийн 6-н айлын орон сууц" барих ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо захиалагчийн хяналтын зардлын санхүүжилт 2.9 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад илүү шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоосон.
- Сайхандулаан сумын "Дотуур байрны их засвар, халаалтыг шинэчлэх ажил"-ын гүйцэтгэлийг санхүүжүүлэхдээ зургийн үнэ төсөвт батлагдаагүй байхад гүйцэтгэгч байгууллагад төлөх санхүүжилтээс хасч зураг төслийн үнэ 4.2 сая төгрөгийг олгосон тул Сант номун ХХК-аар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- Замын-Үүд сумын ИТХ-аар төсөв батлагдаагүй, тендер зохион байгуулагдаагүй, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх эрх шилжүүлсэн ажлын зардалд 58.0 сая төгрөгийг зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Замын-Үүд сум 2020 оны Төв талбайн шинэчлэлт хавтан талбай барих ажлыг Борхойн зам ХХК 218.1 сая төгрөгөөр гэрээ байгуулан хийж дууссан бөгөөд 2020 онд тус ажилд 143.3 сая төгрөг, 2021 онд 86.5 сая төгрөгийг тус тус шилжүүлэн гэрээний дүнгээс 11.7 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Хөвсгөл сумын "ЕБС-ийн үдийн цайны барилын засварын ажил"-ын захиалагчийн хяналтыг сумын Засаг даргын 2021 оны А/80 дугаар захирамжаар сургуулийн багш ажилчдын төлөөлөл томилогдон хийж гүйцэтгэсэн байна. Гэтэл захиалагчийн хяналтын зардлын санхүүжилт 1.1 сая төгрөгийг, мөн зураг төсвийн санхүүжилтийн хэмнэлт 0.1 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад илүү шилжүүлсэн тул Их булаг трейд ХХК-аар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- Сайхандулаан сумын "Дотуур байрны их засвар, халаалтыг шинэчлэх ажил"-ын гүйцэтгэлийг санхүүжүүлэхдээ гүйцэтгэгч байгууллагын магадлашгүй ажлын зардлыг 2.2 сая төгрөгөөр дутуу олгосон тул Хулшанд ХХК-д нөхөн олгохоор албан шаардлага өгсөн байна.

ОНХС-ийн 2021 оны шинээр хэрэгжсэн ТАХ-ний зарцуулалт

Хүснэгт №10 /сая төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих	Гэрээ байгуулсан дүн	Шилжүүлсэн	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=3-4
1	Айраг	542.2	542.2	524.0	444.8	79.2
2	Алтанширээ	496.5	496.5	482.9	386.8	96.1
3	Даланжаргалан	482.3	482.3	404.5	344.9	59.6
4	Дэлгэрэх	413.7	413.7	413.8	364.2	49.6
5	Иххэт	369.1	369.1	331.2	325.7	5.5
6	Мандах	289.7	274.0	288.5	286.4	2.1
7	Өргөн	365.2	365.2	221.4	213.6	7.8
8	Сайхандулаан	519.5	519.5	251.4	251.4	-
9	Улаанбадрах	947.4	885.1	835.5	548.6	286.9
10	Хатанбулаг	923.3	923.3	915.3	911.7	3.6
11	Хөвсгөл	739.3	739.3	260.6	257.2	3.4
12	Эрдэнэ	440.2	401.3	434.9	325.7	109.2
13	Сайншанд	927.8	696.3	865.9	606.1	259.8
14	Замын-Үүд	1,502.5	1,268.2	1,497.3	998.8	498.5
15	Аймаг	3,621.0	3,621.0	3,619.7	3,345.4	274.3
Нийт		12,579.7	11,997.0	11,346.9	9,611.3	1,735.6

Тайлант онд шинээр хэрэгжих арга хэмжээнд 12,579.7 сая төгрөгийг зарцуулахаар баталж, 11,346.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээг байгуулсан нь 1,232.8 сая төгрөгийн хэмнэлт үүсгэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Айраг, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумд 14 ТАХ-г гэрээний хугацаанаас 30-аас дээш хоногоор хоцроож гүйцэтгэсэн ба аудитаар алдангийн хэмжээг тооцоход нийт 60.1 сая төгрөгийн суутгаагүй зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ковид 19 цар тахалтай холбоотойгоор ажлын гүйцэтгэл удааширч, ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэх нөхцөл бүрдээгүйгээс алданги тооцоогүй Айраг, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумдад төлбөрийн акт тогтоолгүйгээр гэрээнд заасны дагуу алдангийг тооцож ажиллах зөвлөмж өгөв.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь сангийн зорилготой уялдсан боловч үр нөлөөг сайжруулах зорилгоор ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.2.1 Зарим ажил бүрэн хэрэгжээгүйгээс төлөвлөсөн зорилтод түвшинд хүрээгүй, үр дүн хангалтгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 12,579.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 155 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, 5,681.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж, 5,615.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 ТАХ-г дутуу хэрэгжүүлэн, 1,282.8 сая төгрөгийн 27 ТАХ огт хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ТАХ-ний хэрэгжилт /тоогоор/

Хүснэгт №11

Д/д	Сумын нэр	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Дутуу хэрэгжсэн	Огт хэрэгжээгүй
1	Айраг	11	9	1	1
2	Алтанширээ	14	13	1	-
3	Даланжаргалан	5	3	1	1
4	Дэлгэрэх	17	14	1	2
5	Иххэт	7	6	-	1
6	Мандах	4	4	-	-
7	Өргөн	3	2	-	1
8	Сайхандулаан	20	11	-	9
9	Улаанбадрах	7	3	2	2
10	Хатанбулаг	10	9	1	-
11	Хөвсгөл	11	6	-	5
12	Эрдэнэ	8	6	1	1
13	Сайншанд	24	19	2	3
14	Замын-Үүд	10	5	4	1
15	Аймаг	4	2	2	-
Нийт		155	112	16	27
Нийт дүнд эзлэх хувь		100%	72%	10%	18%

Дутуу хэрэгжсэн болон огт хэрэгжээгүй ТАХ нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Сайншанд сумын 10.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “3 дугаар багт шинээр сүүдрэвч барих ажил - 4 байрлалд тус бүр 1 ширхэг” сүүдрэвчийг хаврын улиралд байрлуулахаар болсон байна.
- Сайншанд сумын 15.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “7 дугаар багт 136 дугаар /40 айл/ байрны дээврийн засварын ажил” гэрээний хугацаа 2022.06.10-ны өдөр хүртэл сунгасан байна.
- Сайншанд сумын 17.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “3 дугаар багт тэгш гудамж төсөл хэрэгжүүлэх ажил” цахим тендерийг 4 удаа зохион байгуулсан ч оролцогч оролцоогүй байна.
- Сайншанд сумын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “4 дүгээр багийн Ганзамын 34 дүгээр байрны гадна авто зогсоол байгуулах” ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, ажил гүйцэтгэх гэрээг захиалагчийн талаас цуцалсан байна.
- Айраг сумын 64.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын төвд нийтийн бие засах газар байгуулах” ажлыг хугацаа алдаж тендер шалгаруулалт зохион байгуулсан, 2022.05.10-нд гүйцэтгэхээр гэрээг сунгасан байна.
- Даланжаргалан сумын 64.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Биеийн тамирын талбайн засвар тохижилтын ажил” цахим системд нийт 4 удаа тендер шалгаруулалт зарласан боловч оролцогч санал ирүүлээгүйгээс тендер амжилтгүй болсон байна.
- Айраг сумын 66.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дүлийн хогийн цэгийг хашаажуулж, тохижуулах” ажлын гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн байна.
- Сайхандулаан сумын 99.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дотуур байр, төсөвт байгууллагуудын цэвэр усны шугам шинээр хийх” ажил тендерт компани оролцоогүй байна.
- Даланжаргалан сумын 294.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цомог багийн цэвэрлэх байгууламж” ажил нь хөрсний ус ихээр гарснаас ажил удааширч, захиалагчийн хяналтаар зориулалтын сав суулгахаар шийдвэрлэсэн байна.
- Замын-Үүд сумын 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “3 дугаар багийн нутаг дэвсгэрт 584 метр автозамын ажил” санхүүжилт удааширсан шалтгаанаар гэрээний хугацааг 2022.04.01-ний өдөр хүртэл сунгасан байна.

Дутуу хийгдсэн болон хийгдэж байгаа ажлууд



Зураг №1 Хатанбулаг сумын “80 хүүхдийн дотуур байрны камержуулалт” дотор 6 ширхэг, гадаа 2 ширхэг камер байрлуулсан, Сургуулийн агуулахад суурилуулаагүй 10 ширхэг, дутагдсан 1 ширхэг камер байна. Мөн Сумын ЗДТГ нь дотор 3 ширхэг, гадаа 2 ширхэг камерыг суурилуулсан байна, дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр албан шаардлага өгөв.

/2022.04.28-ны өдрийн байдлаар/



Зураг №2 Сайншанд сумын 8 дугаар багт “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлэх ажил /хог хаягдал ангилан ялгах савтай/, төгсгөлийн хашаа хийгдээгүй дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр албан шаардлага өгөв.

/2022.05.06-ны өдрийн байдлаар/



Зураг №3 Замын-Үүд сумын 2.6 км дугуйн зам болон гэрэлтүүлэг барих ажил /хүнд даацын автозам дагуу/ ажил хийгдэж байна. /2022.05.18-ны өдрийн байдлаар/



Зураг №4 Замын-Үүд сумын “Төв саадны засвар” ажил хийгдэж байна. /2022.05.18-ны өдрийн байдлаар/




Зураг №5 Замын-Үүд сумын “Соёмбот цогцолборын засвар шинэчлэлт” ажил хийгдэж байна. /2022.05.18-ны өдрийн байдлаар/



Зураг №6 “Өвс тэжээлийн нөөцийн агуулах барих” ажил хийгдэж байна. /2022.05.19-ний өдрийн байдлаар/



Зураг №7 “Сайншанд сум халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга цэвэрлэх байгууламж барих” ажил хийгдэж байна. /2022.05.22-ны өдрийн байдлаар/



Зураг №8 “Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн гадна дотор инженерийн шугам сүлжээ гадна тохижилт гадна дотно цахилгаан хангамж” ажил хийгдэж байна. /2022.05.22-ны өдрийн байдлаар/

Гүйцэтгэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 28 хувийг хэрэгжүүлээгүй бөгөөд энэ нь ковид 19 халдварт өвчний тархалт, БНХАУ-ын хил тодорхойгүй урт хугацаагаар хаасан зэргээс шалтгаалсан байна.

Тиймээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь зорилтод түвшинд хүрээгүй, зарим ажлын гүйцэтгэл удаашралтай байгаагаас бодит үр дүн гараагүй байна.


2.2.2 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1.4-т “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заасан.

Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн барилга байгууламж, дулаан алдагдлыг бууруулах, өнгө үзэмжийг сайжруулах их засвар, дэд бүтцийн ажил, шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалт, гэмт хэрэг зөрчлийг бууруулах болон урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгийн хамгаалах зорилготой гудамжны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэх, худаг гаргах, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрхүүдэд хашааны болон хог хаягдлын савны стандартыг нэвтрүүлсэн жишиг гудамж, хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх аюулгүй орчин нөхцөл бүрдүүлсэн тоглоомын талбай, ТАХ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай зураг төсвийн ажил, өвсний нөөц бэлтгэх зэрэг чиглэлээр ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжсэн ТАХ-ний ангилал

График №6



Графикаас харахад 3.9-10.3 хувь хүртэл камержуулалт, жишиг гудамж, зураг төсөв, тоглоомын талбай, барилга байгууламж, худаг ус, өвс, гудамжны гэрэлтүүлэг, дэд бүтцийн ажлууд, 18.7 хувийг тоног төхөөрөмж, 25.2 хувийг засварын ажлууд эзэлж байна.

Аймаг, сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тухайн орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, иргэдийн амьдрах ая тухтай орчныг сайжруулахад чиглэгдсэн байна. Тухайлбал:

- Айраг сум - Сумын төвийн шороон замыг тэгшлэх, сумын төвийн засмал замын хажуугаар хашлага хийх ажил;
- Алтанширээ сум - ЕБС-ийн гадна биеийн тамирын талбай барих ажил;
- Даланжаргалан сум – Цомог багийн цэвэрлэх байгууламжийн ажил;
- Дэлгэрэх сум – Сумын төвийн ЦДАШ-ын өргөтгөлийн ажил;
- Иххэт сум – ЕБС-ийн дээвэр, дотуур байрны фасад, сантехникийн ажил;
- Мандах сум – ТАХ-ийн 6 айлын орон сууц;
- Өргөн сум – Сумын төвийн инженерийн төв шугамыг өргөтгөх ажил;
- Сайхандулаан сум – Дотуур байрны их засвар, халаалтыг шинэчлэх ажил;
- Улаанбадрах сум – Сумын төвийн гэр байрны 29 айл өрхийг хашаажуулах ажил;

- Хатанбулаг сум – Нийтийн эзэмшлийн талбайд цэвэр, бохир болон дулааны шугамыг холбох ажил;
- Хөвсгөл сум – Гудамжны гэрэлтүүлэг шинээр нэмж суурилуулах ажил;
- Эрдэнэ сум – Сумын төвийн камержуулалтын ажил, Дөрвөлж багийн иргэдэд үйлчлэх төвийн барилга;
- Сайншанд сум – 1, 2, 3, 8 дугаар багт Хүүхдийн тоглоомын талбай, Хилэнцийн хөшөөний авто зогсоолын ажил;
- Замын-Үүд сум – Нийтийн эзэмшлийн зам талбайн ажил;
- Аймаг – Халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажил.

Сумын төвд хийгдсэн цэвэр, бохир дулааны шугамд холбох, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах, сургууль цэцэрлэгийн барилгад засвар үйлчилгээ хийх зэрэг томоохон ажлууд нь иргэдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, орон нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.1 ОНХС-аар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт хэвийн байгаа боловч зарим худаг усыг тодорхой шалтгааны улмаас бүрэн ашиглахгүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г сумын Засаг даргын захирамжаар ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.


Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Сайншанд сумын 14 ТАХ, Хатанбулаг сумын 10 ТАХ, Эрдэнэ сумын 5 ТАХ, Замын-Үүд сумын 9 ТАХ, нийт 38 ТАХ-ний хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзсэн.

Дээрх хөрөнгийг ашиглагч байгууллага бүрэн ашиглаж байсан ба ашиглалт хангалтгүй, эсхүл ашиглаагүй, илүүдэлтэй хөрөнгө аудитын явцад илэрсэнгүй. Харин Эрдэнэ суманд гаргасан 2 худгийн ус шорвог, тухайн багт зуншлага муу байгаагаас ойр орчимд айл байхгүй, одоогоор ашиглалтгүй байна.

Хөрөнгийн ашиглалтын байдал



Зураг №9 Сайншанд сумын “Автобусны буудал шинээр байгуулах ажил” 1 автобусны буудлыг автомашин мөргөж эвдэлсэн /аудитын явцад засварласан/
/2022.05.06-ны өдрийн байдлаар/



Зураг №10 Замын-Үүд сумын “3 дугаар багт шинээр худаг гаргах барих ажил” ашиглагч малчдаас тодруулга авахад: усны чанар цэвэр, ус муу гардаг, худгийн ойр орчим бэлчээрийн даац муу гэтэл нэг дор 7-8 худаг гаргасан байна.
/2022.05.18-ны өдрийн байдлаар/

Түүвэрт хамрагдсан хөрөнгийн ашиглалт хэвийн, зориулалтын дагуу ашиглаж байна.

2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн хэвийн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-т “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан байдаг.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №12

Д/д	Сумын нэр	Бараа	Ажил	Нийт
1	Айраг	2	7	9
2	Алтанширээ	3	10	13
3	Даланжаргалан	2	1	3
4	Дэлгэрэх	2	12	14
5	Иххэт	-	6	6
6	Мандах	1	3	4
7	Өргөн	-	2	2
8	Сайхандулаан	7	4	11
9	Улаанбадрах	-	3	3
10	Хатанбулаг	3	6	9
11	Хөвсгөл	2	4	6
12	Эрдэнэ	-	6	6
13	Сайншанд	-	19	19
14	Замын-Үүд	1	4	5
15	Аймаг	1	1	2
Нийт		24	88	112

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Сайншанд сумын 14 ТАХ, Хатанбулаг сумын 10 ТАХ, Эрдэнэ сумын 5 ТАХ, Замын-Үүд сумын 9 ТАХ, нийт 38 ТАХ-ний хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг газар дээр нь очиж үзсэн.

Дээрх хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн байсан ба аудитын явцад тус асуудалтай холбоотой материаллаг зөрчил илэрсэнгүй. Харин Сайншанд, Замын-Үүд суманд зарим гэрэлтүүлгийн толгой унасан, Замын-Үүд сумын хогны машины дугуй муудсан байдалтай байсан.

Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал



Зураг №11 Сайншанд сумын “2 дугаар багт гэр хорооллын гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил” 14 дүгээр хэсэгт хийгдсэн 5 ширхэг гэрлийн нэгийг машин мөргөснөөс гэрэл унасан. /2022.05.06-ны өдрийн байдлаар/



Зураг №12 Замын-Үүд сумын “Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-нд хог тээврийн 2 ширхэг автомашин худалдан авах” автомашины дугуй муудаж тросс нь гарсан байна. /2022.05.18-ны өдрийн байдлаар/

Аймаг, сумын ОНХС-аар хийгдсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт зохистой, хэвийн байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг журмын дагуу тайлагнаагүй байна.

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан ч үр дүн хангалтгүй байна.

3.1.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх зөрчил давтагдсаар байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина” гэж тусгажээ.

Сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, ТАХ-ний гүйцэтгэлийн явцад хяналт тавих чиглэлээр хяналтын хороог томилсон боловч, уг хорооноос хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Зарим сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны тайланд хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн ажил, илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийг тодорхой бус тусгасан, хяналт шалгалтад ТАХ-г бүрэн хамруулаагүй байна. Тухайлбал:

- Алтанширээ, Дэлгэрэх, Сайхандулаан, Хөвсгөл сумдууд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-г хяналт шалгалтад бүрэн хамруулаагүй;
- Сайншанд, Даланжаргалан, Замын-Үүд, Хатанбулаг, Эрдэнэ сумаас бусад сумд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэл, хэрэгжилтийн явцыг тайланд тодорхой тусгаагүй;
- Даланжаргалан, Замын-Үүд, Улаанбадрах, Эрдэнэ сумаас бусад сумд хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг тайланд тусгаагүй;
- Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах санал, зөвлөмжийг гүйцэтгэгч болон захиалагчид хүргүүлсэн эсэх тодорхойгүй;
- Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн огноо, давтамж тодорхойгүй;
- Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн гишүүдийн талаарх мэдээлэл тодорхой бус, тайланг гарын үсгээр баталгаажуулаагүй.

Даланжаргалан, Замын-Үүд, Эрдэнэ сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооноос хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэл, чанар байдлыг үнэлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар гүйцэтгэгч компанид санал, зөвлөмж хүргүүлсэн гэх боловч зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ нь 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хяналтын хороог байгуулан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-ний зарцуулалт, үр дүнд хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

ИТХ-ын хяналтын хорооноос хэрэгжүүлсэн хяналт, шалгалтын талаарх нотлох баримт хангалтгүй, илэрсэн зөрчлийн агуулга тодорхойгүй, зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлыг шалгаагүй, хяналтын үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Төрийн аудитын байгууллагаас ОНХС-ийн 2019 оны зарцуулалтад хийсэн аудитаар дээрх зөрчил илэрч, зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлсэн боловч тус зөрчил арилаагүй байна.

Тиймээс ИТХ-аас хэрэгжүүлэх хяналтыг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх, хороодын гишүүдийг арга зүйгээр хангах, хорооны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

3.1.2 Захиалагчийн хяналтыг гүйцэтгэх мэргэжилтэн дутмагаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавина”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 3.9-д “Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна” гэж заажээ.

ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 7,964.4 сая төгрөгийн 88 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр ажлын төсөвт тусгасан боловч 3,293.8 сая төгрөгийн 33 ТАХ-нд хяналтыг гүйцэтгүүлэх гэрээг аймгийн ГХБХБГ болон Сант номун ХХК-тай байгуулжээ.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ

Хүснэгт №13

Д/д	Сумын нэр	Захиалагчийн хяналтын зардал төсөвлөгдсөн ТАХ		Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ		Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй ТАХ	
		тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/	тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/	тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/
1	Айраг	6	366.9	2	193.4	4	173.5
2	Алтанширээ	6	364.1	2	141.5	4	222.6
3	Даланжаргалан	7	722.8	1	112.7	6	610.1
4	Дэлгэрэх	2	80.1	-	-	2	80.1
5	Иххэт	6	331.2	3	148.0	3	183.2
6	Мандах	5	979.0	2	700.5	3	278.5
7	Өргөн	2	221.4	-	-	2	221.4
8	Сайхандулаан	4	189.3	1	145.0	3	44.3
9	Улаанбадрах	5	1,112.3	2	226.5	3	885.8
10	Хатанбулаг	3	714.3	3	714.3	-	-
11	Хөвсгөл	5	242.1	-	-	5	242.1
12	Эрдэнэ	9	447.4	3	188.9	6	258.5
13	Сайншанд	20	837.2	13	717.0	7	120.2
14	Замын-Үүд	8	1,356.3	1	6.1	7	1,350.2
Нийт		88	7,964.4	33	3,293.8	55	4,670.5

Зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ТАХ-ний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх хүсэлтийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлдэг боловч, тус байгууллагаас хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн хариу өгдөг байна. Тиймээс ТАХ-ний хяналтыг захиалагч байгууллага буюу сумдын ЗДТГ нь хэрэгжүүлж, захиалагчийн хяналтыг зардлыг хэмнэсэн байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г тайлант онд бүрэн гүйцэтгээгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай зэргээс шалтгаалж захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ГХБХБГ нь ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-ний захиалагчийн хяналтыг гүйцэтгэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг батлуулснаас эхлэн хяналтыг хэрэгжүүлэн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангуулах, хөдөлмөр хамгаалал, эрүүл аюулгүйн байдлыг хангаж ажиллахад анхаарах, гэрээний хугацаанд хийж гүйцэтгэх гэсэн ерөнхий зөвлөмж шаардлагуудыг хүргүүлсэн байна.

Мандах сумын ОНХС-аас “Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц” барих ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо захиалагчийн хяналтын зардлын санхүүжилт 2.9 сая төгрөгийг, Хөвсгөл сумын ОНХС-аас “ЕБС-ийн барилгын засварын ажил”-ын захиалагчийн хяналтын зардлын санхүүжилт 1.1 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад илүү шилжүүлсэнд 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлэн төлбөрийн акт тогтоон буцаан төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

3.1.3 Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 оны ОНХС-д хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, ... хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина”, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.3-д “төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймаг, сумдын 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагнал, бүртгэлд хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг иж бүрэн, үнэн зөв боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг тайлагнаагүй, журамд заасан холбогдох нотлох баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2, 9.9-д ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сумын ЗДТГ нь дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т, тус хэлтэс нь 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхээр заасан ба тайланд дараах мэдээллийг багтаасан байхаар тусгажээ.

Тодруулбал: ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр, зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр, нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа, шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт, он дамжин хэрэгжүүлэх жагсаалт, сайн туршлага, жишээ, оновчтой санал, шалгалтаар өгсөн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга зэрэг болно.

Сумдаас аймгийн ЗДТГ-т, тус газраас Сангийн яаманд хүргүүлсэн тайланг аудитын явцад хэвлэмэл байдлаар ирүүлээгүй ба зөвхөн хүргүүлсэн тоон мэдээллийг цахимаар ирүүлсэн. Тиймээс цаг хугацаандаа хүргүүлсэн эсэхийг тогтоох боломжгүй байв.

Аймаг болон сумдын тайланд тухайн жилийн батлагдсан төсөв, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг ТАХ тус бүрээр тусгасан байна. Харин дээрх журамд заасан дараах мэдээллийг огт тусгаагүй байна. Үүнд:

- ТАХ-ний байршил, гүйцэтгэлийн хувь, эхлэх болон дуусах хугацаа;
- Ажлын гэрэл зураг, өмчлөлд бүртгэсэн баримт материал;
- Он дамжих хэрэгжих ТАХ-ний жагсаалт;
- Сайн туршлага, оновчтой санал;
- Эрх бүхий болон хууль, хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлэн ажлын мэдээ зэрэг.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлын мэдээллийг журамд заасны дагуу бүрэн тайлагнаагүй, нотлох баримт материалыг бүрдүүлээгүй байгаа нь тухайн арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээлэл иж бүрэн байх зарчмыг хангахгүй байна.

3.2.2.Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгасан байна гэж заасан.

ОНХС-аар хэрэгжүүлсэн, тайлант хугацаанд дууссан арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдлыг дараах хүснэгтэд тусгав.

Нягтлан бодох бүртгэлд тусгах арга хэмжээ

Хүснэгт №14

Үзүүлэлт	Бүртгэлд тусгах арга хэмжээ		Бүртгэлд тусгасан		Бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй тусгасан	
	тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/	тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/	тоо хэмжээ	гэрээний дүн /сая төгрөгөөр/
Шилжин ирсэн ажил	18	2,962.0	12	1,746.7	6	1,215.3
Тайлант онд хэрэгжсэн ажил	100	5,004.2	88	4,302.1	12	702.1
Нийт	118	7,966.2	100	6,048.8	18	1,917.4

Сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 6,048.8 сая төгрөгийн 100 ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан ба 1,917.4 сая төгрөгийн 18 ажлыг дараах сумд тусгаагүй байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын ОНХС-аар хийгдсэн, 65.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 ажил;
- Замын-Үүд суманд хийгдсэн 275.7 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 3 ажил;
- Мандах суманд хийгдсэн 176.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ажил, 322.0 сая төгрөгийн дүнтэй 1 ажлыг 104.8 сая төгрөгөөр тусгаж, 217.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан;
- Өргөн суманд 30.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ажил;
- Сайншанд сумын ОНХС-аар хийгдсэн 49.7 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 5 ажил;
- Эрдэнэ суманд хийгдсэн 113.8 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 2 ажил;
- Аймгийн ОНХС-аар гүйцэтгэсэн 987.8 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 4 ажлыг тус тус бүртгээгүй байна.

Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 3 ТАХ-г анхан шатны баримтыг бүрдэл дутуу шалтгаанаар, 2 ажлыг хөрөнгийн урсгал зардлын асуудал шийдвэрлэгдээгүй шалтгаанаар 2021 онд бүртгээгүй ба тайлант онд бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна.

Замын-Үүд суманд хийгдсэн 2 ажлыг Чандманьбадрал ОНӨХХК бүртгэх байсан боловч татан буугдсан шалтгаанаар бүртгээгүй ба шинээр байгуулагдсан дулааны станцын бүртгэлд тусгах ажил хийгдэж байна.


Санхүүгийн тайланд тусгаагүй 1,884.2 сая төгрөгийн 16 ажлыг ашиглагч байгууллагад бүртгүүлэх хугацаатай 5 албан шаардлагыг аймгийн ОНӨГ болон Замын-Үүд, Сайншанд, Өргөн, Дэлгэрэх сумдын ЗДТГ-т хүргүүлэв.

Сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын анхан шатны баримт бичгийг бүрдүүлэх, ашиглагч байгууллагад шилжүүлэхэд цаг хугацаа алдаж, 2021 онд дууссан ажлыг 2022 оны 5 дугаар сар хүртэл нягтлан бодох бүртгэлд тусгах тохиолдол ажиглагдсан. Мөн ажлын зураг төсөв, хот хөгжлийн төлөвлөгөө зэрэг хөрөнгийг бүртгэхгүй орхигдуулж байна.

3.2.3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний 70 гаруй хувийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, бүрэн мэдээлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3, 3.4-т аймаг, сумдын Засаг дарга УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний мэдээллийг бүрэн оруулахаар заасан.

УМС-д сум тус бүрээр хэрэгжсэн арга хэмжээний тоо, төсөв, санхүүжилтийг нэгтгэн тайлагнах, арга тус бүрээр тайлагнах гэсэн 2 үндсэн талбартай байна.



Зураг №13 ОНХС-ийн УМС: Нэгтгэсэн мэдээллийг харуулсан хэсэг /Дорноговь аймаг-2021 он/

Зарим үзүүлэлтийн аймгийн хэмжээнд нэгтгэсэн нийт дүн нь сумдын нийт дүнгийн нийлбэрээс зөрүүтэй байна. Тухайлбал:

- Аймаг болон сумдын ОНХС-аар хэрэгжсэн ажлын батлагдсан төсвийн нийлбэр нь 14,674.0 сая төгрөг байтал аймгийн нэгтгэлд 19,070.0 сая төгрөг гэж 4,396.0 сая төгрөгөөр илүү тусгасан;
- Санхүүжилтийн төсвийн нийлбэр 6,503.0 сая төгрөг байтал аймгийн нэгтгэлд 14,885.0 сая төгрөг гэж 8,382.0 сая төгрөгөөр илүү тусгасан.

УМС-ийн ТАХ-г дэлгэрэнгүй, ажил тус бүрээр мэдээлэл байршуулах хэсэгт төсөвт өртөг, гэрээний дүн, олгосон санхүүжилтийн дүнг зөрүүтэй байршуулах, эсхүл огт мэдээлээгүй байх, ажлын гэрэл зургийг оруулахгүй байх зэрэг нийтлэг зөрчил илэрсэн.

Сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн нийт 136 ТАХ-ний системд оруулсан мэдээллийг шалгахад 25 хувь буюу 34 арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй, 48 хувь буюу 66 ажлын мэдээлэл зөрүүтэй тусгагдсан, 27 хувь буюу 36 арга хэмжээний тоон мэдээг үнэн зөв тусгажээ.

#	Санхүүжилтийн гүйцэтгэл	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Зарцуулалт	Байршил	Дугаар
1	Нийт	Гуудамны гэрэлтүүлэг номондүүлэх	2021-2021	₮ 45,000,000	₮ 43,815,603	₮ 40,758,885	Здугаар-Бат	Дугаар-Бат
2	Нийт	Худал гэрэлтүүлэг	2021-2021	₮ 67,925,000	₮ 67,000,388	₮ 55,620,874	Здугаар-Бат	Дугаар-Бат
3	Хэрэгжүүлсэн	Тогтоомын тайлбайтай болох	2021-2021	₮ 30,000,000		Шалтгаан: Төсөвт өртөг хураагүй тул хасалдсан		
4	Нийт	Дуурын замтай болох	2021-2021	₮ 486,758,000	₮ 478,940,106	₮ 381,518,208	1, 2, 3, 4, 5-бүс багт	Дугаар-Бат
5	Нийт	Замыг нөхөн сэргээх	2021-2021	₮ 430,000,000	₮ 429,840,106	₮ 268,139,578	Здугаар-Бат	Дугаар-Бат
6	Нийт	Тэгш гудамж төсөл	2021-2021	₮ 100,000,000	₮ 99,999,205	₮ 69,999,513	3-болом 5-дугаар баг	Дугаар-Бат
7	Нийт	Сөөмбө цогцолборын засвар шинэчлэлтийн ажил	2021-2021	₮ 188,000,000	₮ 188,700,000	₮ 151,835,274	1-дугаар баг	Дугаар-Бат
8	Нийт	Төв саядны засварын ажил	2021-2021	₮ 75,721,000	₮ 75,628,245	₮ 35,277,381	1, 2, 3, 4, 5-бүс багт	Дугаар-Бат
9	Нийт	Хотны машины тоог нэмэгдүүлэх	2021-2021	₮ 130,000,000	₮ 127,499,000	₮ 127,499,000	1-дугаар баг	Дугаар-Бат
10	Нийт	Гэр хороололд шулам сүтээх нэмж тавих	2021-2021	₮ 35,000,000	₮ 34,602,180	₮ 17,301,080	1, 2, 3, 4, 5-бүс багт	Дугаар-Бат
11	Хэрэгжүүлсэн	Сүлд байгын өмнө цуглааны урд баригдах хүүдний тайлбайн ажил	2021-2021	₮ 40,000,000		Шалтгаан: Төсөвт өртөг хураагүй тул хасалдсан		
12	Нийт	Нийтийн эзэмшлийн зам тайлбайн тохиожилтийн ажил	2021-2021	₮ 13,500,000	₮ 13,500,000	₮ 12,168,000	1, 2, 3, 4, 5-бүс багт	Дугаар-Бат

Зураг №14 ОНХС-ийн УМС: арга хэмжээг дэлгэрэнгүй харуулсан хэсэг

ОНХС-ийн мэдээллийн систем, түүнд байршуулах мэдээлэлтэй холбоотой дараах асуудлыг шийдвэрлэж, арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

Үүнд:

- Батлагдсан төсөв хэсэгт байршуулах мэдээлэл нь ажлын төсөвт өртөг, эсхүл тайлант онд олгохоор батлагдсан санхүүжилтийг тусгах нь тодорхойгүй;
- Хэрэгжиж буй ажлын тоонд ИТХ-аар батлагдсан боловч тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй ажлыг оруулах эсэх;

- Дэлгэрэнгүй жагсаалтад тусгасан тоон мэдээлэл нь нийт дүнгээрээ нэгтгэсэн хэсэгт тусгасан тоон мэдээллээс зөрүүтэй;
- Ажил эхлэхээс өмнөх, явцын болон дууссаны дараах гэрэл зургийг мэргэжилтэн бүрэн оруулсан боловч гадны хандалтаар зураг харагдахгүй, дутуу харагдаж байгаа асуудал;
- Зарцуулалт буюу олгосон санхүүжилтийн дүн хэсэгт ажлын гүйцэтгэгчид шилжүүлсэн төлбөрөөс гадна, захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн этгээдэд олгосон төлбөрийг тусгах эсэх асуудал;
- Он дамжин хэрэгжиж буй ажлыг системд хэрхэн тусгах, батлагдсан төсөв, гэрээний дүнд эдгээр ажлын мэдээллийг нэгтгэх эсэх зэрэг.

Системд ТАХ-ний мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулах, холбогдох мэдээллийг бүрэн байршуулахад шат шатны холбогдох албан хаагчид хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ТАХ-ний мэдээллийг бүрэн байршуулахгүй, зөрүүтэй мэдээлэх нь иргэд, олон нийт үнэн зөв мэдээллээр хангагдах, тэдний зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх эрсдэлтэй байна.

3.2.4 Сангийн хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд Шилэн дансны системд мэдээлсэн боловч зарцуулалтыг бүрэн мэдээлэх шаардлагатай байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.14-т “худалдан авах ажиллагааны жилийн тайланг ... дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор ... мэдээлнэ гэж заасан байна.

Худалдан авах ажиллагааны жилийн тайланг Хатанбулаг сумаас бусад бүх сумд болон аймаг хууль, журамд заасан хугацаанд мэдээлсэн байна. Гэвч тайланд тусгасан зарим ажлын гэрээний дүн зөрүүтэй, төсөвт өртөг, гэрээний дүнг мөнгөний нэг ижил нэгжээр илэрхийлээгүй /мянган төгрөгөөр, төгрөгөөр/, гүйцэтгэгч байгууллагын нэр, гэрээ байгуулсан болон дүгнэсэн, урилга нийтэлсэн огноо зэргийг орхигдуулсан байна. Алтанширээ сум тайланд мэдээллийг ажил тус бүрээр бүрэн оруулж, тайлбар, тодруулгыг дэлгэрэнгүй, ойлгомжтой тусгасан байна.

Хатанбулаг сумын 2021 оны худалдан авах ажиллагааны тайланд тусгагдсан 923.3 сая төгрөгийг өртөг бүхий 10 ажлын мэдээллийг нөхөж байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Мөн дээрх журмын 3.1.15-д “орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор ...мэдээлнэ” гэж тусгажээ.

ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт сумд сар, жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг цаг хугацаандаа оруулсан байна. Гэвч ТАХ-ний дэлгэрэнгүй жагсаалтад зарим сумдад дараах мэдээллийг зөрүүтэй тайлагнасан байна.

Үүнд:

- Айраг сум жилийн гүйцэтгэлийг мэдээлээгүй ба ХАА-ний төлөвлөгөөний файлыг хавсаргасан;
- Алтанширээ сум олгосон санхүүжилтийн хэмжээг мэдээлээгүй;
- Даланжаргалан сум зарим ажлын олгосон санхүүжилтийн хэмжээг дутуу мэдээлсэн;
- Дэлгэрэх сум ТАХ-ний төсөвт өртгийн хэмжээг анхны батлагдсан төсвөөр оруулсан ба дахин шинэчлээгүй;
- Мандах сум санхүүжилтийн хэмжээг ажил тус бүрээр тусгаагүй, нийт дүнгээр мэдээлсэн;
- Өргөн сум олгосон санхүүжилтийн хэмжээг мэдээлээгүй;
- Сайншанд сум төсөвт өртгийн хэмжээг мянган төгрөгөөр илэрхийлсэн боловч бусад үзүүлэлтийг төгрөгөөр мэдээлсэн.

Мөн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт байршуулах мэдээлэл нь зарим сумдад зөрүүтэй, төсвийн гүйцэтгэлийг оруулах талбар тусгагдаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

ОНХНС-аас аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилж, бүрэн шилжүүлсэн байна.

ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө гадаад, дотоодын хандив тусламжийн орлогыг боломжит хэмжээгээр төлөвлөөгүй, өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн татварыг зарим сумын ОНХС-ийн эх үүсвэрт тусгаж батлаагүйгээс холбогдох ТАХ-г бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хязгаарласан байна.

Сумд ОНХС-ийн эх үүсвэрээр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч ИНХ-аар хэлэлцүүлэх ажил хийгддэг ч зарим сумд иргэдээс санал авч эрэмбэлээгүй ажлыг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаж, тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарсан байна.

Төсөв тооцоо хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын гаргасан батлагдсан зураггүй ТАХ-г тухайн сумын ИТХ нь баталж, дараа нь зураг төсвийг хийлгэж байгаа нь төсөвт өртөгт дахин өөрчлөлт орох, үр ашиггүй хөрөнгө бий болох эрсдэлийг үүсгэж байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ил тод байдлыг хангах зорилгоор тухайн нутаг дэвсгэрийн иргэний төлөөллийг оролцуулаагүй байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын шалтгаанаар тайлант онд хэрэгжүүлсэн зарим ажил төсөл арга хэмжээг гүйцэтгэх гэрээний хугацаа хэтэрсэн байхад захиалагч алданги тооцоогүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 155 ТАХ хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 112 ТАХ бүрэн хэрэгжиж, 16 ТАХ дутуу хэрэгжиж, 27 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Тухайн шатны ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хороодыг томилсон ч төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн үе шатанд тухай бүр тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 59 хувь буюу 4,670.5 сая төгрөгийн 55 ажилд захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг иж бүрэн боловсруулаагүй, холбогдох баримтыг хавсаргаагүй, Сангийн яаманд хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын 15 хувь буюу 1,812.6 сая төгрөгийн 17 ажлыг бүртгэлд тусгаагүй, 322.0 сая төгрөгийн 1 ажлыг 104.8 сая төгрөгөөр буюу 217.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

Удирдлагын мэдээллийн системд нийт ТАХ-ны 27 хувийг үнэн зөв, 48 хувийг зөрүүтэй тусгаж, 25 хувь буюу 34 ажлыг огт мэдээлээгүй байна.

ОНХС-ийн УМС-ийн ашиглалт, зарим мэдээллийн байршуулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэж, арга зүйгээр хангах шаардлагатай байна.

Шилэн дансны цахим системд тайлан, мэдээг хуулийн хугацаанд байршуулсан боловч сангийн зарцуулалтын мэдээллийг зарим сумд зөрүүтэй мэдээлжээ.

Аудитаар нийт 2,753.3 сая төгрөгийн 59 зөрчил илрүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх, дутуу ажлыг гүйцэтгүүлэх, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх зэрэг нийт 2,753.3 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, холбогдох албан тушаалтнуудад 47 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Б.ГАНЗОРИГ ТАНАА:

1. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.2.2-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, хяналт шалгалт хэрэгжүүлсэн баримт нотолгоог чанаржуулан ажиллах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлэх хандивын орлогыг үндэслэлтэй тооцож, бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
3. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д “заасан мэдээллийг аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланд бүрэн тусгаж, баримтжуулах”, 11.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” заалтыг хэрэгжүүлж ажиллах.
4. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, байршуулсан мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хянах, арга зүйгээр хангаж ажиллах.

АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож байх.
3. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
2. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
2. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ... орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
4. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
2. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож байх.
4. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

САЙХАНДУЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдлийг эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

4. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ... орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
5. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ... орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ... орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
4. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож байх.

5. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г санхүүжүүлэхийг хориглоно гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
4. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож байх.
5. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцож, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төлөвлөж ажиллах.
2. Төсөл арга хэмжээг батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
3. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож байх.
2. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

№1



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2022.06.03 № 03/738
танай 2022.06.02-ны № 1-6/458 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн
аудитын тайланг хүлээн авч танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой нэмэлт саналгүй
болно.

ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

4403220622
D/2021/toot-A5

№2



Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (705) 2-30-09, Факс: (705) 2-31-40,
Цахим шуудан: dornogobi.ith@gmail.com

2022.06.02 № 08/46
танай 2022.06.02-ны № 1-6/459 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас газрын тухай хуулийн Танай байгууллагаас 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1-6/459 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой санал байхгүй болно.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Ц.БАТСУГИР

448220389

№3



ДОРНОГОВЬ АЙМАГ
САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА

Сайншанд сумын ЗДТГ-ын байр, Залуучуудын гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/факс: (705) 2-24-40

Цахим хаяг: www.sainshand.do.gov.mn

2022.06.02 № 02/465
танай 2022.06.02 -ны № 1-6/460 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Дээрх тайлантай холбоотой санал байхгүй.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  ДТӨМӨРБААТАР



4462200882

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/15

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” тушаалын 3.2, 18.9, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

010010096

-2-

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2022 оны 06 дугаар сарын 1-ны өдрийн
А/15 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

Д/д	Огноо, дугаар	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Хариуцах албан тушаалтан
1	2022.06.03 234/А1070617 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Зөрчлийг арилгах тухай /иргэдийн саналаар дэмжигдээгүй/	82,337,948	Иххэт сумын Засаг дарга, Засаг даргын орлогч
2	2022.06.03 235/А1070617 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Зөрчлийг арилгах тухай /иргэдийн саналаар дэмжигдээгүй/	540,344,600	Улаанбадрах сумын Засаг дарга, Засаг даргын орлогч
3	2022.06.03 236/А1070617 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Зөрчлийг арилгах тухай /иргэдийн саналаар дэмжигдээгүй/	235,137,400	Хөвсгөл сумын Засаг даргын орлогч
4	2022.06.03 237/А1070296 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх тухай	5,000,000	Хатанбулаг сумын Засаг дарга, Засаг даргын орлогч
5	2022.06.03 238/А1070296 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх тухай	6,363,000	Сайншанд сумын Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТ-ийн дарга
6	2022.06.03 239/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Данс бүртгэлд тусгуулах тухай	1,495,436,655	Орон нутгийн өмчийн газрын дарга
7	2022.06.03 240/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Данс бүртгэлд тусгуулах тухай	275,740,634	Замын-Үүд сумын ЗДТГ-ын дарга
8	2022.06.03 241/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Данс бүртгэлд тусгуулах тухай	16,470,000	Сайншанд сумын ЗДТГ-ын дарга
9	2022.06.03 242/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Данс бүртгэлд тусгуулах тухай	30,500,000	Өргөн сумын ЗДТГ-ын дарга
10	2022.06.03 243/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Данс бүртгэлд тусгуулах тухай	65,943,993	Дэлгэрэх сумын ЗДТГ- ын дарга
11	2022.06.03 244/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Зөрчлийг арилгах тухай /удирдлагын мэдээллийн систем/	-	Аймгийн ЗДТГ-ын дарга, ХОХБТХ-ийн дарга
12	2022.06.03 245/А1070299 ДГА- 2022/30-7-ШТА-ГА	Зөрчлийг арилгах тухай /Шилэн данс/	-	Хатанбулаг сумын Засаг даргын орлогч
Нийт			2,753,274,230	-

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХЯНАСАН:	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Т.ГАН-ӨЛЗИЙ
АУДИТЫН МЕНЕЖЕР	У.ОЮУНТҮЛХҮҮР

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

АХЛАХ АУДИТОР	Т.МӨНХТОГТОХ
АУДИТОР	Д.ДЭМБЭРЭЛСҮРЭН
АУДИТОР	Ч.ХЭРЛЭНЧИМЭГ
АУДИТОР	Б.АЛТАНЗУЛ